# ДӨРВӨН УУЛ ХК

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, АЯЛЛЫН БАРАА, БҮТЭЭГДХҮҮН, МОТОЦИКЛ,
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ХУДАЛДАА, АГУУЛАХ, ТҮРЭЭС, ҮЙЛЧИЛГЭЭ

**Огноо :2019.03.24** **Улаанбаатар хот**

## ДӨРВӨН УУЛ ХК-ИЙН 2018 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

### АГУУЛГА


НЭГ: БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА
- Жилийн үйл ажиллагааны тойм
- Зах зээл

ХОЁР: УДИРДЛАГЫН БАГ
- Төлөөлөн удирдах зөвлөлийн баг
- Гүйцэтгэх удирдлагын баг

ГУРАВ: САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ
- Санхүүгийн тайлан
- Зээлийн мэдээлэл

ДӨРӨВ: ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ
- Хувьцаа эзэмшигчид
- Хувьцааны арилжаа
- Зах зээлийн үнэлгээ

ТАВ: НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ
- Ногдол ашиг

**Огноо :2019.03.24** **Улаанбаатар хот**

## НЭГ: БИЗНЕСИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТОЙМ БА ЗАХ ЗЭЭЛ

1. ӨМНӨ нь: Амгалангийн оёдлын үйлдвэр гэж байсан бөгөөд өмч хувьчлалаар "ДУ"ХК нь хувьчлагдсан болно.
   - Барилга нь хуучирсан
   - Төвийн дулаан шугам байхгүйгээс халаалтын асуудлаа шийдэж чадахгүй байсан.
   - Зах зээлийн байдлаас болж үйлдвэрүүд бүгд зогсонги байдалд орсноор оёдлын үйлдвэр цаашид ажиллах боломжгүй болсон, өөрийн орлогогүй болсон.
2. ОДОО: Өөрчлөлт шинэчлэлт хийсэн АЛХАМ:

"Дөрвөн Уул" ХК-ий үйл ажиллагааг сэргээх, үйл ажиллагааг хэвийн болгохын тулд дараах ЗОРИЛТУУД-ыг тавьсан.
Нэг: Удирдлагын менежментийг сайжруулах
Хоёр: Газар болон Үл хөдлөх хөрөнгийг оновчтой ашиглах
Гурав: Үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөн өргөжүүлэх
Дөрөв: Боломж дээр түшиглэн зах зээлийг мэдэрч ажиллах
Тав:"ДУ" ХК нь ажилтан, албан хаагчидтай болж Санхүүгийн тайлан, НДШ, ХХОАТ-аа тайлагнаж хэвийн үйл ажиллагаатай болох

Нэг: Удирдлагын менежментийг сайжруулах ажлын хүрээнд:

"ДУ"ХК-ий 76,51 хувийг том хувьцаа эзэмшигч нар болох С.Од-Эрдэнэ, О.Мөнх-Эрдэнэ, Ц.Одгэрэл нар эзэмшиж "ДУ" ХК-ий удирдлагын эрх шилжигдэж 2014 оны 5-р сарын 20-ны өдөр УБүртгэлийн шинэ ГЭРЧИЛГЭЭ-г дахин авч Удирдлагын эрхийг албан ёсоор шилжүүлснийг бүртгүүлсэн болно.

Хоёр: Газар болон Үл хөдлөх хөрөнгийг оновчтой ашиглах ажлын хүрээнд:

**Огноо :2019.03.24** **Улаанбаатар хот**

Үндсэн хөрөнгийн ерөнхий байдал маш муу байсан. Байр ашиглалтын асуудлыг хэвийн болгоход нэмэлт хөрөнгө гарган засвар хийхэд гол анхаарлаа төвлөрүүлэн ажилласан.

Гурав: Үйл ажиллагааны чиглэлийг өөрчлөн өргөжүүлэх ажлын хүрээнд:

1. ҮХЭХ-ийг түрээслэн орлого олж байгаа
2. Аялал жуулчлалын чиглэлээр үйл ажиллагаагаа өргөжүүлэх бэлтгэл ажил хийгдсэн
3. Бараа бүтээгдэхүүнийг борлуулж ашиг олж байгаа
4. Хүний нөөцийг нэмэгдүүлж баг бүрдүүлж өргөжсөн
5. Бэлтгэн нийлүүлэгчээс авах бараа бүтээгдэхүүний төрөл, тоог олшруулан ашиг нэмэгдүүлэх дэс дараатай алхмуудыг хийж байгаа
6. Дулааны асуудлаа шийдэхийн тулд төвийн шугамтай холбох асуудлыг судалж, төсөл боловсруулан ажиллаж байгаа боловч хөрөнгө санхүүгийн байдлаас болж зогсонги байдалтай байгаа болно.
7. Дөрвөн Уул ХК-ийн үйл ажиллагааны орлого нэмэгдүүлэхэд аялал жуучлалын хэрэгсэл болон хөзөр борлуулах үйл ажиллагааг үргэлжлүүлэн худалдааны судалгаа хийж эхэлсэн. Цаашид нэр төрлийг өргөжүүлэн “out-door” төрлийн барааг борлуулан худалдах төлөвлөгөөтэй ажиллаж байна.

Дөрөв: Боломж дээр түшиглэн зах зээлийг мэдэрч ажиллах

1. ДУ ХК-ийн ҮХЭХ-ийг оновчтойгоор, үр ашигтай түрээслүүлж ашиг олохын тулд Түрээсийн ААН байгууллага түншийг олсон бөгөөд хамтарч ажиллаж байгаа
2. Хашаандаа Машин зогсоолтой болж, хураамжаар орлого олох боломжийг судалж байгаа

Тав:”ДУ” ХК нь ажилтан, албан хаагчидтай болж Санхүүгийн тайлан, НДШ, ХХОАТ-аа тайлагнаж хэвийн үйл ажиллагаатай болох зорилтуудын хүрээнд:

1. ”ДУ” ХК нь Санхүүгийн тайлангаа илгээж тайлагнадаг болсон

**Огноо :2019.03.24** **Улаанбаатар хот**

2. НДШ-ийг төлж тайланг тогтмол илгээдэг
3. Өөрийн гэсэн орлоготой болж үйл ажиллагаа тогтмолжих, өргөжих төлөвтэй болсон зэрэг дэвшилт гарсан болно.

ДӨРВӨН УУЛ ХК-нь хөзөр борлуулалтын 8 нэгжтэй хамтран ажилласан. Ажлын байр түрээсийн 2 аж ахуйн нэгжтэй хамтран ажиллаж байна.

## ХОЁР: УДИРДЛАГЫН БАГ

Төлөөлөн удирдах зөвлөлийн баг
Гүйцэтгэх удирдлагын баг

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН БАГ
ДӨРВӨН УУЛ ХК-ийн ТУЗ нь 9 гишүүнтэй бөгөөд үүнээс 3 гишүүн нь хараат бус гишүүд юм.
ТУЗ нь:

1. С.Од-Эрдэнэ
2. О.Мөнх-Эрдэнэ
3. О.Энх-Эрдэнэ
4. Б.Гэрэлмаа
5. П.Буянжаргал
6. Ц.Одгэрэл

Хараат бус гишүүд

7. О.Цэрэннадмид
8. Н.Мэндсайхан
9. Д.Сумъяа

**Огноо :2019.03.24** **Улаанбаатар хот**

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН БАГ

Гүйцэтгэх захирлыг ТУЗ-өөс сонгодог. П.Буянжаргал 2018 онд гүйцэтгэх захирлаар томилогдож ажилласан.

## ГУРАВ: САНХҮҮГИЙН МЭДЭЭЛЭЛ

Санхүүгийн тайлан ба Зээлийн мэдээлэл

Эргэлтийн хөрөнгө өмнөх оны мөн үеэс 103,9 % буюу 18,149.1 мянган төгрөгөөр өссөн бөгөөд эргэлтийн бус хөрөнгөд төдийлөн өөрчлөлт ороогүй болно. Нийт өр төлбөрийн хувьд зээлийн төлөлт хийгдээгүй байгаа байгаа бөгөөд өмнөх оноос өссөн байдалтай байна.

Санхүүгийн байдал

| | 2016 | 2017 | Оны эхнээс |
|---|---|---|---|
| | *Гүйцэтгэл* | *Гүйцэтгэл* | |
| **Эргэлтийн хөрөнгө** | **17,460.3** | **35,609.4** | **103,9%** |
| **Эргэлтийн бус хөрөнгө** | **502,545.1** | **502,545.1** | |
| **Нийт Хөрөнгө** | **519,975.4** | **538,154.5** | **3,5%** |
| **Өр төлбөр** | **450,667.2** | **520,160,0** | **15,4%** |
| **Эздийн өмч** | **69,308.2** | **17,994.5** | **-74%** |
| **Нийт өр төлбөр ба ЭӨ** | **519,975.4** | **538,154.5** | **3,5%** |

Балансын бүтцийн хувьд эргэлтийн хөрөнгө өмнөх оноос өсөж, эргэлтийн бус хөрөнгийн бүтэц төдийлөн өөрчлөгдөөгүй бөгөөд нийт өр төлбөр буюу зээл өссөн, эздийн өмч буурсан.

ОРЛОГО ҮР ДҮН

FOUR MOUNTAIN

# ДӨРВӨН УУЛ ХК

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, АЯЛЛЫН БАРАА, БҮТЭЭГДХҮҮН, МОТОЦИКЛ,
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ХУДАЛДАА, АГУУЛАХ, ТҮРЭЭС, ҮЙЛЧИЛГЭЭ

**Огноо :2019.03.24** **Улаанбаатар хот**

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад орлого 242,6%-иар өссөн нь хөзөр болон камин зуух зээлээр авч гэрээт борлуулагч хийсэн, түрээсийн орлого нэмэгдсэнтэй холбоотой болно. Хэдийгээр орлого өссөн мэт харагдаж байгаа ч зардал 179,9%-иар өссөн байна. Энэ нь нам даралтын зуух дэлбэрч халаалтыг цахилгаанаар шийдсэнтэй холбоотойгоор ашиглалтын зардал өссөн. Мөн хүний нөөц нэмэгдсэнээр цалингийн зардал өссөнтэй холбоотой.

Орлого үр дүн /мянган төгрөгөөр /

| | 2017 | 2018 |
|---|---|---|
| | **Гүйцэтгэл** | **Гүйцэтгэл** |
| **Цэвэр борлуулалтын орлого** | **34,469.2** | **118,113.1** |
| **Борлуулсан бүтээгдэхүүний өртөг** | | **42,330.7** |
| **Нийт ашиг** | **34,469.2** | **75,782,4** |
| **Үйл ажиллагааны зардал** | **(45,367.3)** | **(126,994.4)** |
| **Үйл ажиллагааны ашиг** | | |
| **Үйл ажиллагааны бус ашиг, алдагдал** | | |
| **Татвар төлөхийн өмнөх ашиг** | **(10,898.1)** | **(51,212.0)** |
| **Татварын зардал** | | |
| **Татварын дараах ашиг** | | |

ЗЭЭЛИЙН МЭДЭЭЛЭЛ /мянган төгрөгөөр /

| д/д | Зээлийн зориулалт | Авсан огноо | Төлсөн огноо | 2017 он | 2018 он |
|---|---|---|---|---|---|
| 1 | Хуучин барилгыг засварлаж, өргөтгөл | 2012 оноос эхлэн | Төлөгдөж эхлээгүй | 430,731.3 | 451,223.1 |

**"Дөрвөн-Уул" ХК.** РД: **2095971. Баянзүрх дүүрэг 8-р хороо.** Амгаланбаатар-32. **Ш/Х-**210348а-22. **e-mail:** finance.fourmountain@gmail.com
Утас: **+976 70164545, 98980011, 98980012. Facebook.com/totalmotorsmongolia**

**Огноо :2019.03.24** **Улаанбаатар хот**

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | барих, гадна талбайн тохижилт хийхэд | санхүүжилт зээлээр | байгаа | | |
| 2 | Бараа материал зээлээр авч худалдан борлуулсан | 2015 оноос эхэлсэн | Төлөгдөж эхлээгүй байгаа | 19,770.3 | 65,271.6 |
| | Зээлийн үлдэгдэл ДҮН: | | | 450,501.6 | 516,494,7 |

2018 оны 4-р улирлын байдлаар нийт 516,494,676 төгрөгний зээлийн үлдэгдэлтэй байна.

## ДӨРӨВ: ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН МЭДЭЭЛЭЛ

Хувьцаа эзэмшигчид
Хувьцааны арилжаа
Зах зээлийн үнэлгээ

ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧИД

| Хувьцаа эзэмшигчид | Эзэмшлийн % |
|---|---|
| **Ц.Одгэрэл** | **36,13%** |
| **О.Мөнх-Эрдэнэ** | **14,21%** |
| **С.Од-Эрдэнэ** | **26,17%** |
| **Бусад** | **23,49%** |
| **Нийт** | **100%** |

# ДӨРВӨН УУЛ ХК

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, АЯЛЛЫН БАРАА, БҮТЭЭГДХҮҮН, МОТОЦИКЛ,
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ХУДАЛДАА, АГУУЛАХ, ТҮРЭЭС, ҮЙЛЧИЛГЭЭ

**Огноо :2019.03.24** **Улаанбаатар хот**

## ХУВЬЦААНЫ АРИЛЖАА, ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

2018 оны 1-р сараас 2018 оны 12-р сарын 31ны байдлаар Дөрвөн Уул ХК-ийн хувьцаа нийт 217 ширхэг буюу 418,493 төгрөгийн арилжаа хийгдсэн. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад тоо хэмжээний хувьд бага боловч нэгжид ногдох үнийн дүнгээр өссөн үзүүлэлт юм. Харин хувьцааны ханшийн 2018 оны дунд үед өсөж 2,300 төгрөг хүрч арилжаалагдсан бол оны сүүлээр буурч 1,300 төгрөг байгаа бөгөөд энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 20,9%-иар буурсан байна.

| | 2017 | 2018 | Өсөлтийн хувь |
|---|---|---|---|
| Хаалтын ханш, төгрөг | 1,643 | 1,300 | -20,9% |
| Хувьцааны тоо | 633 | 217 | -65,7% |
| Нийт үнийн дүн, төгрөг | 636,596 | 418,493 | |

"Дөрвөн-Уул" ХК. РД: 2095971. Баянзүрх дүүрэг 8-р хороо. Амгаланбаатар-32. Ш/Х-210348а-22. e-mail: finance.fourmountain@gmail.com
Утас: +976 70164545, 98980011, 98980012. Facebook.com/totalmotorsmongolia

# ДӨРВӨН УУЛ ХК

АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛ, АЯЛЛЫН БАРАА, БҮТЭЭГДХҮҮН, МОТОЦИКЛ,
ТОНОГ ТӨХӨӨРӨМЖИЙН ХУДАЛДАА, АГУУЛАХ, ТҮРЭЭС, ҮЙЛЧИЛГЭЭ

**Огноо :2019.03.24** **Улаанбаатар хот**

Saved from:
http://mse.mn/mn/company/21





**“Дөрвөн-Уул” ХК.** РД: **2095971. Баянзүрх дүүрэг 8-р хороо.** Амгаланбаатар-32. **Ш/Х**-210348а-22. **e-mail:** finance.fourmountain@gmail.com
Утас: **+976 70164545, 98980011, 98980012. Facebook.com/totalmotorsmongolia**

**Огноо :2019.03.24** **Улаанбаатар хот**

**<u>ТАВ: НОГДОЛ АШГИЙН МЭДЭЭЛЭЛ</u>**

2018 оны Ногдол ашиг хуваарилахгүй байхаар шийдвэрлэсэн болно.
Шалтгаан нь:

1. Үйл ажиллагаа дөнгөж тогтворжиж, эхлэлтийн байдалтай байгаа
2. Ашигтай ажиллаагүй
3. Орлого бага
4. Өр зээлтэй
5. Хамгийн их зардал гарч байгаа нь цахилгааны зардал
6. Ажилчид, хүний нөөц нэмэгдсэнээр цалингийн зардал өссөн
7. Дулаан хангамжинд асуудал үүссэнээр 2018 оны эхэн болон сүүл өвлийн саруудад үйл ажиллагаа зогсонги байсан.

**Анхаарал хандуулсанд баярлалаа**